

Үндэсний статистикийн салбарын 2013 оны үйл ажиллагааны тайлангийн хураангуй	2
Нэг. Монгол Улсын статистикийн салбарын 2013 оны зорилго, зорилтын хэрэгжилт, үр дүн	7
1.1 Эдийн засгийн статистикт олон улсын нийтлэг, шинэ стандартыг нэвтрүүлэх бэлтгэлийг бүрэн хангах	8
1.2 Нийгмийн статистикийн үзүүлэлтүүдийн цогц байдлыг бүрдүүлж, судалгааны уялдааг хангах	12
1.3 Төрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоонд уялдсан салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулж, статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархаах шинэ технологи нэвтрүүлэх	18
1.4 Чанарын удирдлагын механизмыг бүрдүүлэн нэвтрүүлж эхлэх	21
1.5 Салбарын ажилтнуудын мэргэжлийн болон менежментийн ур чадварыг дээшлүүлж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх	25
Хоёр. Монгол Улсын статистикийн салбарын удирдлага, зохион байгуулалт, гадаад харилцаа, төсөв, 2014 оны зорилго, зорилт	31
Гурав. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны “Байгууллагын чиг үүрэг”-г хийгдсэн системчилсэн үнэлгээ	40
Хавсралт 1. ҮСХ-ны Даргын Зөвлөлийн хурлаар шинээр болон шинэчлэн батлагдсан аргачлал, үзэл баримтлал	55

*Монгол Улсын
статистикийн салбарын
2013 оны үйл ажиллагааны
тайлангийн хураангуй*

Үндэсний статистикийн салбарын хэмжээнд 2013 оныг “Статистикийн хэрэглэгчдийг эрэлт хэрэгцээнд нь нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах шинэчлэлийн жил” болгох үндсэн зорилго дэвшүүлж “Статистикийн тухай” хуулинд заагдсан тооллого, судалгааг зохион байгуулалт сайтай, чанартай явуулж, статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилт, анхдагч мэдээллийн чанарт онцгойлон анхаарч ажиллалаа.

❖ Албан ёсны статистикийн мэдээллийн мэдээлэгчид учрах ачааллыг багасгах, мэдээллийн давхардлыг арилгах, нэгдмэл байдлыг хангах, шуурхай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр:

- Монгол Улсын “Статистикийн тухай” хуулинд 2013 онд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа болон Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаануудыг нэгтгэн “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа” нэртэй нэгдсэн судалгаа явуулж байхаар хууль эрх зүйн өөрчлөлт хийлээ.
- Эрх зүйн энэхүү өөрчлөлтийн дагуу дээрх судалгааг нэгдсэн аргачлалаар улсын хэмжээнд 15.5 мянган өрхийг хамруулан судалгааны мэдээлэл цуглуулдаг байсан асуулгын хуудас нөхөх уламжлалт аргаар бус орчин үеийн технологийн дэвшил болох таблет ашиглан зохион байгуулсан нь ихээхэн хүн хүч, хөрөнгө, цаг хугацаа хэмнэсэн төдийгүй судалгааны мэдээллийг тухай бүр интернетээр татаж авах бололцоо бүрдүүлж мэдээллийг чанартай, богино хугацаанд нэгтгэн гаргах боломжтой боллоо.
- Мал тооллогын мэдээллийг онлайн программаар багийн түвшинд шивж, ҮСХ-ны серверт боловсруулдаг болсон нь цаг хугацаа хэмнэсэн, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан чухал арга хэмжээ болсон юм.

❖ Арга зүйн нэгдмэл байдлыг хангах, олон улсын түвшинд нийтлэг мөрдөж байгаа болон мөрдөхөөр зөвлөмж болгосон шинэ, шинэчилсэн арга зүйг нэвтрүүлэх, статистикийн аргачлал, арга зүйг улам боловсронгуй болгох чиглэлээр:

- “Үндэсний тооцооны систем-2008”-д шилжих бэлтгэл хангагдаж, үндэсний тооцооны үндсэн 4 багц аргачлал болох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), үндэсний нийт орлого (ҮНО)-ыг тооцох, ДНБ-ийг улирлаар тооцох, Үндэсний тооцооны данс байгуулах, Нөөц ашиглалтын

хүснэгт, салбар хоорондын тэнцлийг зохиох аргачлалуудыг шинэчлэн батлууллаа.

- Нөөц ашиглалтын хүснэгт (НАХ), салбар хоорондын тэнцэл (СХТ)-ийг 2010 оны гүйцэтгэлээр ҮТС-2008 зөвлөмжийн дагуу байгуулж, түүнд суурилсан судалгаа, шинжилгээ хийж, макро түвшний тооцооллын хүрээг өргөжүүлж, НАХ-д суурилан 2005-2012 оноор ДНБ-ий тооцооллыг улирлаар, үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар, оны болон зэрэгцүүлэх үнээр шинэчлэн хийв.
- Ядуурлын үзүүлэлт тооцох арга зүйг боловсронгуй болгох чиглэлээр Дэлхийн банктэй хамтран ажиллаж, ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийн шууд харьцуулагдах боломжийг бүрдүүллээ.
- Нийгмийн статистикийн арга зүйг боловсронгуй болгох хүрээнд боловсрол, соёл, шинжлэх ухаан, жендэр, гадаад шилжих хөдөлгөөний статистикийн арга зүй болон боловсролын ангиллыг шинэчлэн боловсруулав.

❖ Албан ёсны статистикийн үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглаж, олон улсын төдийгүй өөрийн улсад албан ёсны статистик мэдээллийн чанар, үнэн зөв бодит байдлыг хангах чиглэлээр:

- Үндэсний Дата Төвд статистикийн мэдээллийн сангийн архив болон ҮСХ-ны вэб сайт, e-мэйл хаягийг шилжүүлэн байршуулсан ба төрийн нэгдсэн сүлжээнд холбогдох бэлтгэл ажлыг хангасан байна.
- Статистик нэгжийн олон улсын стандартад нийцсэн мэдээллийн санг сүлжээний орчинд серверт байрлуулан, албан ёсны статистикийн мэдээллийг ачаалах, засвар, өөрчлөлтийг тусгах, ашиглах, үр дүн гаргах “Цогц программ хангамж” боловсруулж, бизнес регистрийн үйл ажиллагаанд программчлалыг нэвтрүүлэн, бизнес регистрийн санг ашиглах боломжийг бүрдүүллээ.
- ҮСХ-ноос эрхлэн гаргадаг статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнүүд болон статистик мэдээллийн нэгдсэн санг iOS-оос гадна Android төхөөрөмж ашиглан Monstat, ezStat аппликейшнүүдээр хэрэглэх боломжтой болов.
- Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийг сайжруулах, нэгдсэн сан байгуулах, улмаар хүн ам, өрхийн бүртгэлийн нэгдсэн сантай болж, хүн амын дотоод болон гадаад шилжих хөдөлгөөнийг тооцон, статистикийн судалгаа хийх чиглэлээр Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-ын мэдээллийн сантай дээрх сангуудыг уялдуулан шалгах, шаардлагатай тайлан мэдээг гаргаж авах ажлыг эхлүүлээд байна.
- Тооллого, судалгааны анхдагч шатны мэдээллийг нууцлал, аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр хэрэглэгчдэд нээлттэй болгосноор ӨНЭЗС, АХС, Хүүхэд хөгжил судалгаа, НАХ, Салбар хоорондын тэнцэл гэх мэт 25 төрлийн тооллого судалгааны задгай мэдээллийн сан, мета мэдээллийг монгол, англи хэлээр авах боломжтой болсон.

-
- Орон нутгийн албад болон олон улсын сургалт семинар, онлайн хурал хийх программ хангамжийн тохиргоо бүрдүүлж, нийслэл, 21 аймгийн статистикийн газар, хэлтсүүдтэйгээ тогтмол видео хурал хийдэг боллоо.
- ❖ Албан ёсны статистикийн чанарын удирдлагыг нэвтрүүлэх, бэхжүүлэх, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр:
- Монгол Улсын статистикийн салбарт “Албан ёсны статистикийн чанарын бодлого”-ыг тодорхойлж, “Албан ёсны статистикийн чанарын удирдлагын стандарт хэм хэмжээ” албан баримт бичгийг батлуулж, “Хэрэглэгчид зориулсан статистикийн чанарын тайлан боловсруулах зөвлөмж” боловсруулав.
 - Статистикийн салбарт ҮСХ-ноос батлан, мөрдөж буй аргачлал, арга зүйн зөвлөмжүүдэд үнэлгээ, мониторинг хийгдлээ.
 - Анхан шатны нэгжид цуглуулж, дамжуулж буй албан ёсны статистик мэдээллийн чанарыг сайжруулах болон орон нутгийн салбарын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Ховд, Дорнод аймгуудын статистикийн хэлтэст цогц үнэлгээ хийсэн болно.
- ❖ Салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр:
- Салбарын хүний нөөцийг давтан сургах, мэргэшүүлэх зорилго бүхий “Статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудын сургалтын хөтөлбөр”-ийн дагуу 2013 онд статистикийн төв, орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагуудын 48 ажилтныг МУИС, ХААИС-ийн багш нарын оролцоотой гурван шатны мэргэшүүлэх тусгай хөтөлбөрт- сургалтад хамруулав.
 - Баг, хорооны түвшинд статистикийн мэдээ тайлан хариуцсанажилтнуудад статистикийн аргачлал, арга зүйн талаар мэдлэг төлөвшүүлэх, гарын авлагаар хангах, статистикийн үйл ажиллагааг таниулан сурталчлах сургалтыг нийт 20 аймгийн 1580 гаруй ажилтнуудыг хамруулан зохион байгуулав.
 - Давхардсан тоогоор нийт 151 албан хаагчдыг 61 удаагийн гадаад сургалт, семинар, арга хэмжээнд зохион байгуулагч болон олон улсын байгууллага, Монстат төслийн санхүүжилтын дэмжлэгтэйгээр оролцуулсан болно.
- ❖ Статистикийн мэдээллийн үйлчилгээг цогц байдлаар хэрэглэгчдэд хүргэх, хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр:
- Мэдээллийн үйлчилгээ, хүртээмжийн ажлыг өргөжүүлж, тооллого судалгааны үр дүнг олон нийтэд өргөн сурталчлах зорилгоор тус хорооны ТЗУГ-ын дэргэдэх Мэдээллээр үйлчлэх төвийг “Мэдээлэл, сургалт, сурталчилгааны төв” (МССТ) болгон шинэчлэн зохион байгуулж ажиллав.

-
- Хэрэглэгч орон зай, цаг хугацаанаас үл хамааран хүссэн мэдээллээ авч ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор статистикийн мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn)-нд ҮСХ-ноос явуулсан тооллого, түүвэр судалгаануудын нууцлалыг хангасан задгай мэдээллийг байршуулж, үнэ төлбөргүй хэрэглэх боломж бүрдүүлэв. Түүнчлэн 1212 лавлах утсыг ажиллуулж байна.
 - Хэрэглэгчийн бүртгэлийн санд бүртгэгдсэн хэрэглэгчийн e-мэйл хаягаар холбогдох мэдээлэл тогтмол явуулж байна.
 - Статистикийн өдрийг тохиолдуулан ҮСХ-ны удирдлага, орон нутгийн статистикийн хэлтсүүдээс “Статистик хөгжилд хөтлөгч хүч” сэдэвт хичээлийг анх удаа 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр нийслэл, 21 аймгийн ерөнхий боловсролын 49 сургуулийн ахлах ангийн 3500 гаруй сурагчдыг хамруулан хөтлөн явууллаа.
 - Статистикийн мэдээллийн ашиглалтыг сайжруулах, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр УИХ-ын гишүүдийн туслах, Тамгын газрын Хяналт, үнэлгээний болон, Судалгааны хэлтсийн ажилтнуудад, хөдөө орон нутгийн номын санч нар, ХААИС-ийн оюутнууд зэрэгт зориулан “Статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn, EzStat, Monstat апп-аас статистикийн тоон мэдээллийг ашиглах” сэдэвт сургалт зохион байгуулав.
- ❖ ҮСХ нь хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн дэлхийн статистикийн системд үзүүлэх хувь нэмрээ нэмэгдүүлэх чиглэлээр:
- ҮСХ нь НҮБ-ын Статистикийн комисс (НҮБСК)-ын албан ёсны гишүүнийхээ хувьд олон улсын статистикийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгарч буй олон асуудлуудыг шийдвэрлэхэд илүү идэвхтэй, амжилттай оролцож буй бөгөөд үүнд Австралийн Статистикийн Товчоотой хамтран “Нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн Улаанбаатар хотын бүлэг”-ийг санаачлан батлуулсан бөгөөд тайлант хугацаанд тус бүлгийн удирдах зөвлөл болон шинжээчдийн уулзалтуудыг зохион байгуулж, уул уурхайн салбарын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нийт 214 статистик үзүүлэлтийг тодорхойллоо.
 - ҮСХ-ны хүсэлтийн дагуу НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (НҮБЕЭЗК)-оос Монгол Улсын үндэсний статистикийн системд цогц үнэлгээ хийхээр НҮБЕЭЗК-ын Статистикийн хэлтэс, НҮБ-ын АНДЭЗНК, Европын Чөлөөт Худалдааны Ассоциаци, Норвегийн Статистикийн газрын төлөөлөгчдөөс бүрдсэн мэргэшсэн үнэлгээний баг ажилласан нь Ази Номхон Дайлан бүсийн хувьд олон улсын цогц үнэлгээнд хамрагдсан анхны орон болов.
 - Америк, Ази, Номхон Далайн орнуудын үндэсний тооллого, статистикийн байгууллагуудын захирлуудын нийгэмлэгтэй хамтран Хүн ам, орон сууцны тооллогын асуудлаарх олон улсын 26-р бага хурлыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа.

-
- Дэлхийн банкны “Улс орнуудын статистикийн байгууллагын чадавхи”-ийн жил бүрийн үнэлгээгээр 2013 онд тус улсын үндэсний статистикийн чадавхийн ерөнхий дундаж оноо 83 болж дэлхийн дунджаас 15 нэгжээр, статистикийн аргачлалаар 70 болж 12 нэгжээр, мэдээллийн эх үүсвэрээр 100 болж 35 нэгжээр тус тус дээгүүр үнэлэгдэх боллоо.
 - ❖ Тайлант онд тус Хорооны зохистой үйл ажиллагааны үр дүнд улсын төсвийн болон төслийн хөрөнгийн 1.9 тэрбум төгрөгийн бодит хэмнэлтийг буй болгосон бөгөөд түүнийг статистикийн салбарын үйл ажиллагааг бэхжүүлэх, ажилтнуудын нийгмийн асуудал, ажиллах нөхцөл, техник хангамжийг сайжруулахад зарцуулах санал гаргасныг УИХ-ын дарга дэмжсэн болно.

Статистикийн алба үүсч хөгжсөний 90 жилийн түүхт ой тохиож байгаа 2014 он бидний хувьд онцгой жил бөгөөд Үндэсний статистикийн хорооноос статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, Монстат төслийн үйл ажиллагааг амжилттай дуусгах, салбарын түүхт ойгоо өндөр бүтээлээр угтах үүднээс 2014 онд **“Орон нутгийн статистикийн албадын чадавхийг бэхжүүлж, анхдагч мэдээллийн чанарт ахиц дэвшил гаргах”** үндсэн зорилгыг дэвшүүлж байна.

Монгол Улсын статистикийн салбарын 2013 оны зорилго, зорилтын хэрэгжилт, үр дүн

Улсын Их Хурлын 2011 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т статистикийн салбарын үйл ажиллагааны үндсэн зорилтыг “... нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, олон улсын нийтлэг арга зүйд тулгуурласан, нийгмийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох шуурхай, үнэн бодитой тоо мэдээлэл, статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хэрэглэгчдийг хангахад чиглэгдэнэ” гэж тодорхойлсон билээ. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр салбарын хэмжээнд 2013 онд дараах зорилтуудыг дэвшүүлж тэдгээр зорилтуудад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Үүнд:

1. Эдийн засгийн статистикт олон улсын нийтлэг, шинэ стандартыг нэвтрүүлэх бэлтгэлийг бүрэн хангах;
2. Нийгмийн статистикийн үзүүлэлтүүдийн цогц байдлыг бүрдүүлж, судалгааны уялдааг хангах;
3. Төрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоонд уялдсан салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулж, статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархах шинэ технологи нэвтрүүлэх;
4. Чанарын удирдлагын механизмыг бүрдүүлэн нэвтрүүлж эхлэх;
5. Салбарын ажилтнуудын мэргэжлийн болон менежментийн ур чадварыг дээшлүүлж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх

1.1 Эдийн засгийн статистикт олон улсын нийтлэг, шинэ стандартыг нэвтрүүлэх бэлтгэлийг бүрэн хангах

Үндэсний тооцооны системийн хүрээнд хийсэн ажлууд

“Үндэсний тооцооны систем - 2008”-д шилжих бэлтгэл хангагдаж, үндэсний тооцооны үндсэн 4 багц аргачлал болох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), үндэсний нийт орлого (ҮНО)-ыг тооцох аргачлал, ДНБ-ийг улирлаар тооцох аргачлал, Үндэсний тооцооны данс байгуулах аргачлал, Нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийг зохиох аргачлалыг шинэчлэн батлууллаа.

Макро түвшний тооцооллын хүрээг өргөжүүлж, үндэсний тооцооны үйлдвэрлэлийн, орлого бүрдэлтийн, орлогын анхны хуваарилалтын, орлогын дахин хуваарилалтын, орлого ашиглалтын, хөрөнгийн гадаад эдийн засгийн дансуудыг 2012 оны гүйцэтгэлээр байгуулж, ДНБ-ий 2012 оны урьдчилсан гүйцэтгэлийг салбаруудаар тооцсоноос гадна орлогын болон эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий 2012 оны урьдчилсан гүйцэтгэлийн тооцоог хийж, бюллетень, жилийн эмхэтгэлд оруулан тархаалаа. ДНБ, ҮНО-ын 2012 оны жинхэнэ гүйцэтгэлийг үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар, оны болон зэрэгцүүлэх үнээр, салбараар, аймгаар, өмчийн хэлбэрээр тооцож, ДНБ-ий 2013 оны улирлын гүйцэтгэлийг оны болон зэрэгцүүлэх үнээр, мөн улирлын чанартай тохируулга тооцоог хийж хэрэглэгчдэд хүргэсний дээр нэг хүнд ногдох ҮНО, ДНБ-ий 2012 оны гүйцэтгэлийг Дэлхийн банкны атласын аргаар тооцсон болно.



2010 оны гүйцэтгэлд суурилсан 12 дэд матриц болон баланслагдсан НАХ, СХТ-ийг байгуулав.

Улс орны эдийн засгийн тэнцвэрт харьцаа, салбарын бүтэц, уялдаа, хэрэглээ, хуримтлал, экспорт, импорт зэрэг эдийн засгийн хөгжлийн үндсэн асуудалд макро түвшинд үнэлгээ өгөх статистик шинжилгээний суурь мэдээлэл болох нөөц ашиглалтын хүснэгт (НАХ), салбар

хоорондын тэнцэл (СХТ)-ийг зохиох бэлтгэл ажлыг 2011 онд эхлүүлж, 2 жил гаруйн хугацаанд боловсруулалтын бүх үе шатны ажлыг гүйцэтгэж, үр дүнгээ гаргалаа. Энэ удаагийн тэнцэл нь “ҮТС-2008 зөвлөмж”-ийн хүрээнд хийгдсэн анхны тэнцэл бөгөөд тэнцлийг зохиоход олон улсад мөрдөгдөж буй ангиллын хамгийн сүүлийн хувилбаруудыг ашиглаж, мэдээллийн “хангалттай” эх үүсвэрт суурилсан тэнцэл болсон гэдгээрээ онцлог юм. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш Салбар хоорондын тэнцлийг 1997, 2000, 2005 онуудад зохиосон бөгөөд энэ удаагийн тэнцлийн үр дүн нь бүх шатны хэрэглэгчид, түүн дотроо судалгаа, шинжилгээний байгууллагууд, бодлого боловсруулагчдад суурь мэдээлэл нь болох бөгөөд улс орны хөгжлийн өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлтийг өгч, хөгжлийн хэтийн төлөвийг тооцож, тодорхойлоход шаардагдах мэдээллийн үндсэн эх сурвалж нь болж байна.

Хэрэглээний үнийн бүсийн индексийг 2013 оноос анх удаа шинээр тооцон сарын бюллетеньд оруулж, нийтийн хүртээл болгосон ба хэрэглээний үнийн улсын индексийг шинэчилсэн жин, суурьтайгаар ХЗХБҮА /Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал/-ын 3 оронгийн түвшинд тооцсон бөгөөд түүнчлэн сумдад зориулсан зурагт каталоги оруулсан болно. Гадаад худалдааны индекс, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, барилгын өртгийн болон жижиглэн худалдааны индексүүдийг тооцож, үр дүнг нэгтгэн тархаалаа.

**Албан ёсны статистикийн
мэдээ тайлан, судалгаа,
танилцуулга, тэдгээрийн
үр дүнгийн тархаалт**

Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдлын статистикийн мэдээг 7, 15 хоног, сар, улирал, жилийн давтамжтайгаар нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтэс болон төрийн захиргааны байгууллага, яамд, агентлагуудаас батлагдсан хуваарийн дагуу хүлээн

авч боловсруулан нэгтгэж бюллетень, танилцуулгыг бэлтгэн тархаалаа. Үүнд: Төсөв, мөнгө, санхүү, гадаад худалдаа, үнэ, төлбөрийн тэнцэл, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, барилга, тээвэр, холбоо, шуудан, дотоод худалдаа, зочид буудал, зоогийн газар, аялал жуулчлал, бизнес регистр, хүн ам, эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухаан, нийгмийн даатгал, халамж, ажил эрхлэлт, ажилгүйдэл, дундаж цалин, өрх, нийгмийн үзүүлэлтүүд, гэмт хэрэг, тогтвортой амьжиргаа, орон сууц, нийтийн аж ахуй, сүм хийд, хилээр орсон гарсан иргэдийн мэдээ зэрэг албан ёсны статистикийн 260 төрлийн 101,5 мянган мэдээ, тайланг /давхардсан тоогоор/ нэгтгэн боловсруулж, хэрэглэгчдэд хүргэлээ. Нийгэм, эдийн засгийн салбарын жилийн эцсийн мэдээг нэгтгэн, “Статистикийн эмхэтгэл 2012”-ыг 29 бүлэг, 350 гаруй дэлгэрэнгүй үзүүлэлтээр бэлтгэн 2000 хувь хэвлэж, эмхэтгэлийн CD 200 хувь хийж хэрэглэгчдэд хүргэж www.nso.mn сайтад тавьсан. 2012 оны байдлаар 21 аймгийн үндсэн 67 үзүүлэлтээр мэдээллийг нэгтгэн гаргаж хэрэглэгчдэд үйлчиллээ.

**Албан ёсны статистикийн мэдээ, тайлан
/2009-2013 он/**



Хөдөө аж ахуйн 2012 оны улсын анхдугаар тооллогын нэгдсэн болон үндсэн үр дүнг Улсын комиссын хурал болон Засгийн Газрын хурлаар хэлэлцүүлж Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 84 тоот тушаалаар эцсийн дүнг баталгаажуулсан болно. Тооллогын үр дүнгээр “Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллого, нэгдсэн

үр дүн”, “Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллого, үндсэн үр дүн” гэсэн 2 төрлийн тайланг боловсруулж, нэгтгэсэн танилцуулгын хамт хэрэглэгчдэд хүргүүллээ.

Улс орны нийгэм, эдийн засгийн төлөв байдлын талаарх албан ёсны статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох ажлын хүрээнд ҮСХ-ноос шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйгээр цогц үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Улсын Их Хурлын 2011 оны 12 сарын 01-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 3.4 хэсэгт “Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, хамралт, мэдээллийн чанар, аргачлал, арга зүйг сайжруулах” зорилт тавигдаж, уг зорилтын хүрээнд “Далд эдийн засгийг тодорхойлох” талаар багагүй ажил гүйцэтгэлээ. Үндэсний тооцооны хамралтыг нэмэгдүүлж, эдийн засгийн цар хүрээг бүрэн хэмжээгээр тодорхойлох, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдыг шаардлагатай бодит тоон мэдээллээр хангах, далд эдийн засгийн талаарх олон улсын түвшинд зэрэгцүүлэгдэхүйц мэдээллийг бий болгох үндсэн зорилго бүхий “Далд эдийн засгийн судалгаа”-г 2012 онд зохион байгуулж явуулсан бөгөөд судалгааны дүнгээр нэгдсэн тайланг бэлтгэж



нийтэд түгээсэн юм. Монгол Улсын далд эдийн засгийн өнөөгийн байдал, дүр төрхийг нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдтэй холбон судалсан энэхүү судалгааны үр дүн нь төрөөс далд эдийн засгийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэх, цаашид хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг боловсруулахад чухал хувь нэмэр болох юм. Мөн энэхүү судалгааг явуулснаар далд эдийн засгийн талаарх үндэсний хэмжээний мэдээллийн сантай болж, ҮСХ-ны боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан явдал болов. Судалгааны үр дүн нь далд эдийн засаг, үүний

дотор албан бус сектор болон албан бус ажил эрхлэлтийн талаарх бодит мэдээллээр хэрэглэгчдийг хангахын зэрэгцээ энэ чиглэлээр ажилладаг судлаач, эрдэмтдэд сүүлийн үеийн шинэ мэдээлэл бүхий гарын авлага боллоо.

Монгол Улсын эдийн засагт уул уурхайн салбар голлох байр суурь эзлэх болсон энэ цаг үед “Бичил уурхайн судалгаа”-г нэгдсэн арга зүй, зарчмаар явуулж, үр дүнг нэгтгэсэн нь салбарын үйл ажиллагааг бүхэлд нь тооцож, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тодорхойлоход ихээхэн чухал ач холбогдолтой боллоо. 2012 онд зохион байгуулж явуулсан уг судалгаа нь уул уурхайн салбарт албан болон албан бусаар хөдөлмөр эрхэлж буй иргэдийг хамарсан тусгайлсан судалгаа болж, судалгааны үр дүнд үндэслэн газар зүйн мэдээллийн санг бүрдүүлж чадсанаараа судалгааны чухал үр дүн, онцлог нь болж байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэд болон тэдгээртэй хамааралтай бүхий л үйл ажиллагааг газар зүйн байршлаар нь үнэн зөв тогтоож, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд тэдний оруулж буй хувь нэмрийг бодитой тодорхойлсон энэхүү судалгааны үр дүн нь бодлого боловсруулагчдад шийдвэр гаргах суурь мэдээлэл болж байна.

Бизнес регистрийн мэдээллийн чанарыг сайжруулахад чиглэгдсэн том болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тусгайлсан судалгаа явуулж, өөрчлөлт хөдөлгөөнийг бизнес регистрийн санд тусгалаа. Сүлжээний орчинд серверт байрласан, статистик нэгжийн олон улсын стандартад нийцсэн мэдээллийн санг зохион байгуулж, албан ёсны статистикийн мэдээллийг ачаалах, засвар, өөрчлөлтийг тусгах, ашиглах, үр дүн гаргах ЦОГЦ ПРОГРАММ ХАНГАМЖ боловсруулж, бизнес регистрийн үйл ажиллагаанд программчлалыг нэвтрүүлж, бизнес регистрийн санг ашиглах боломжийг бүрдүүллээ. Статистик нэгжийн санг Татварын ерөнхий газар (ТЕГ), Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ) зэрэг бусад эх үүсвэрүүдтэй автоматаар шалгаж, засварлах программ хангамжийн бодлогын даалгавар боловсруулж, ТЕГ, УБЕГ-ын мэдээллийн сангаар бизнес регистрийн санг 7 хоног, улирал бүр шинэчлэх боломж бүрдсэн юм.

1.2 Нийгмийн статистикийн үзүүлэлтүүдийн цогц байдлыг бүрдүүлж, судалгааны уялдааг хангах зорилтын хүрээнд:

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодит байдлыг тодорхойлох, олон улсын байгууллагуудын шаардлага, жишигт нийцсэн мэдээллийг бүрдүүлэх, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдыг үнэн бодит мэдээллээр шуурхай хангах зорилгоор улс орны хэмжээнд явуулдаг тооллого, судалгааны хамрах хүрээ, хэмжээ, давтамж өөрчлөгдөж байгаатай уялдаатайгаар “Статистикийн тухай” хуулийн “Тооллого, судалгаа явуулах” гэсэн 7 дугаар зүйлд өөрчлөлт оруулах шаардлагатай болсон юм. Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн “е”-д хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн түүвэр судалгааг 5 жил тутам, “ж”-д хүүхэд хөгжил судалгааг 4 жил тутам зохион байгуулж явуулахаар хуульчилсан байдаг.

Монгол Улс Мянганы хөгжлийн зорилт, Хүүхдийн эрхийн конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, НҮБ-ын ерөнхий Ассамблейн ХДХВ/ДОХ-ын асуудлаар тусгай чуулганы тунхаглал зэрэг олон улсын гэрээ, конвенцид нэгдсэн НҮБ-ын гишүүн орны хувьд эдгээр судалгааг тогтоосон давтамжтайгаар явуулж, холбогдох мэдээллийг бүрдүүлж байна. Түүнчлэн, УИХ-аас баталсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт, Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Засгийн газраас баталсан Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, Хүүхдийн эрхийн нийтлэг шалгуур үзүүлэлт зэрэг үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд нялхас, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээл, дархлаажуулалт, өсөлт, хөгжил, хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, төрөлт, төрөх үеийн тусламж, үйлчилгээ, үр хөндөлт, жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ, БЗДХ, ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, гэр бүл төлөвлөлт, бэлгийн зан үйл болон нөхөр, эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд зэрэг шаардлагатай цогц мэдээллийг буй болгож ашигладаг билээ.

Монгол Улс Хүүхэд хөгжил судалгаа (Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа-ОУБТС)-г 1996, 2000, 2005, 2010 онуудад ОУБТС-ны Дэлхийн хөтөлбөрийн аргачлалд тулгуурлан 4 удаа, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааг 1998, 2003, 2008 онуудад Хүн ам зүй, эрүүл мэндийн Олон улсын судалгааны аргачлалыг баримтлан 3 удаа зохион байгуулсан бөгөөд Хүн ам зүй, эрүүл мэндийн бие даасан судалгааг хараахан явуулаагүй байна.

Хүүхэд хөгжил судалгаа (ХХС), Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа (НҮЭМС) нь хоорондоо 2 жилийн зайтайгаар ихээхэн хөрөнгө, хүн хүч, цаг хугацаа зарцуулан явагддаг төдийгүй судалгааны аргачлалууд зарчмын зөрүүгүй, нийт 49 бүлэг үзүүлэлт тооцдоггоос 28 нь ижил, хоёулаа бүсийн түвшинд үр дүнгээ тархаадаг. Түүнчлэн, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний 4 дэх хөтөлбөрт Нөхөн үржихүйн эрүүл мэнд болон Хүн ам зүй, эрүүл мэндийн нэгдсэн судалгаа явуулахаар заасан нь нэг талаас НҮЭМ-

ийн 2013 оны судалгааны хөтөлбөртэй давхцаж байгаа юм. Нөгөө талаас НҮБ-ын Хүүхдийн сангаас Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийг 2015 онд тайлагнаж, хэлэлцэхэд шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэх зорилгоор Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгааны Дэлхийн 5 дахь хөтөлбөрийн хүрээнд ХХС-г 2014 оны эхний хагаст багтаан зохион байгуулахаар зөвлөмж болгосон нь судалгаануудыг нэгтгэж, боловсронгуй болгох зайлшгүй шаардлагыг бий болгосон. Тиймээс энэ удаа Хүүхэд хөгжил, Нөхөн үржихүйн эрүүл мэнд болон Хүн амын эрүүл мэндийн судалгааг нэгтгэн **“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа” нэртэйгээр 5 жил тутамд зохион байгуулахаар Монгол Улсын “Статистикийн тухай” хууль дахь нэмэлт өөрчлөлтийг** 2013 оны 7 сарын 3-ны өдрийн УИХ-аар баталлаа.


“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013”-ын зорилго нь Дэлхийн Мянганы хөгжлийн зорилт, Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, НҮБ-ын ерөнхий Ассамблейн ХДХВ/ДОХ-ын асуудлаар тусгай чуулганы тунхаглал, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний дөрөв дэх хөтөлбөр болон “Хүүхдийн эрхийн нийтлэг шалгуур үзүүлэлт”-ийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн тооцож, дүгнэх, үнэлгээ өгөхөд оршино.



“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа” нь 2013 оны 9 сарын 30-наас эхэлж, 21 аймгийн 236 сум, 384 багийн 10000 өрх, нийслэлийн 9 дүүргийн 114 хорооны 5500 өрхийг хамран явагдлаа.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-г улс даяар 2013 оны 9 сард 15500 өрхийн хэмжээнд явуулахдаа мэдээлэл цуглуулалтад орчин үеийн техникийн дэвшил болох таблет төхөөрөмжийг анх удаа ашигласнаар судалгааны мэдээллийг тухай бүр интернетээр татаж авах бололцоо бүрдүүлснээс гадна мэдээллийн чанарыг нэмэгдүүлж, богино хугацаанд үр дүнг нэгтгэх боломж бүрдэн, судалгаанд зарцуулагдах зардлыг хэмнэж, 140 ширхэг таблет төхөөрөмжөөр салбартаа томоохон хөрөнгө оруулалт хийлээ. Энэ нь тус хорооноос судалгааны мэдээлэл цуглуулалтад томоохон алхам

болж, цаашид хийх судалгаануудыг технологийн шинэ дэвшил ашиглан зохион байгуулах бололцоо бүрдэж байгаа юм.



“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013”-ын мэдээлэл цуглуулахад орчин үеийн зөөврийн тоног төхөөрөмж болох таблетыг анх удаа ашиглав.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)

Үндэсний хэмжээний томоохон судалгааны нэг болох “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны дүнд үндэслэн тус улсын хүн амын амьжиргааны байдал, ядуурлын түвшинг улс, бүс нутаг, суурьшлаар тооцон тодорхойлж байна. Сүүлийн жилүүдэд ҮСХ,

Дэлхийн Банктай статистикийн боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, хүн амын амьжиргаа, ядуурлын үзүүлэлтийг тооцох арга зүйг сайжруулах чиглэлээр нягт хамтран ажиллаж, Монгол Улсын хүн амын амьжиргаанд гарч буй өөрчлөлтийг бодитоор харуулж чадахуйц арга зүйг тодорхойлон өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэлд тулгуурлан Монгол улсын хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлж, үр дүнг шинжлэн анализ дүгнэлт гаргаж олон нийтэд танилцуулдаг болсон юм.

Хүн амын ядууралтай холбоотой асуудал нь улс орон бүрийн чухал асуудлуудын нэг бөгөөд ядуурлыг бууруулах чиглэлээр олон улс орон, олон улсын байгууллагууд хамтран ажилласаар ирсэн юм.

Тус хорооноос ӨНЭЗС-нд хамрагдах өрхүүдийн түүвэр хийх, мэдээллийг шалгах, нэгтгэх, мэдээллийн бааз үүсгэх, мэдээлэл боловсруулах, үр дүн гаргах, үр дүнгийн тайлан бичих, тархаах зэрэг бүх үе шатны ажлыг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай зардлын тооцоог сар бүр хийж, улирал бүр сонгогдсон 2808 өрхийн судалгааг нийслэл, 21 аймгийн статистикийн газар, хэлтэстэй хамтран, бүрэн хамралттайгаар гүйцэтгэж, судалгаанд хамрагдсан нийт 12811 өрхийн мэдээллийн санг бүрдүүлээд байгаа билээ.

Ядуурлын үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал, амьжиргааны доод түвшний тооцооны арга зүйг шинэчлэн батлуулж, өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2012 оны үр дүнгээс ядуурлын үзүүлэлтүүдийг Дэлхийн банктэй хамтран тооцож “Монгол улс дахь ядуурлын дүр төрх-2012” 7 бүлэг, 90 хүснэгт, 146 нүүр тайланг хэвлүүлж тархаалаа.

Ажиллах хүчний болон Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа (АХС/ХХС)

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажилгүйдлын шалтгааныг улирал бүр тодорхойлон гаргаж, ажиллах хүчний шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд болон бүс нутаг, аймаг, нийслэлээр тооцож, нийгмийн шаардлагатай, үнэн бодит статистикийн мэдээллийг бий болгох зорилгоор ажиллах хүчний судалгаа (АХС)-г 2006 оноос эхлэн улирал бүр явуулж ирлээ.

АХС/ХХС-нд хамрагдах өрхүүдийн түүвэр хийх, мэдээллийг шалгах, нэгтгэх, мэдээллийн бааз үүсгэх, мэдээлэл боловсруулах, үр дүн гаргах, үр дүнгийн тайлан бичих зэрэг бүх үе шатны ажлыг нэгтгэн зохион байгуулдаг юм. АХС-ны 2012 оны мэдээллийн сангаас үр дүнгийн 78 хүснэгт боловсруулж, хүн амын ажил эрхлэлтийн байдлын 95 нүүр тайланг бичиж нийтийн хүртээл болгов.

Ажиллах хүчний судалгааны 2012 оны үр дүнг 16 үзүүлэлтээр аймгийн түвшинд гаргаж, бүх аймаг, нийслэл, дүүргүүдэд хүргүүлсэн бөгөөд аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын тоо, дундаж цалин орлого, ажлын цагийн үргэлжлэл, ажиллах хүчний бүрэлдэхүүний 2012 оны 4 дүгээр улирал, 2013 оны 1, 2, 3 дугаар улирлын тайлангуудыг нийслэл, аймгуудаас хүлээн авч шалган, статистикийн бюллетень, танилцуулгад оруулсан ба Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягт, мэдээллийн сангийн бүтэцтэй уялдуулан цалингийн /ЦС-1/ мэдээ, нийгмийн даатгалын сангийн үзүүлэлтийн харьцуулалт хийж, цалингийн мэдээллийг нийгмийн даатгалын сангаас гаргадаг болохоор ажиллаж байна.

Ажиллах хүчний судалгаатай хамт олон улсын жишиг аргачлалын дагуу хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний судалгааг явуулж, 2011-2012 оны ХХС-ны үр дүнгийн 300 ширхэг, 138 хуудас тайланг монгол, англи хэл дээр хэвлүүлэн тархаав.

Ажиллах хүчний судалгаа нь олон улсад мөрдөж буй нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн, сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийн аргачлалаар тооцох замаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг тодорхойлон, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд, бүс нутаг, хот, хөдөө, аймаг, нийслэл, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлаар улирлын нөлөөллийг тусган тооцож гаргадгаараа чухал ач холбогдолтой.

Хүүхдийн хөдөлмөрийн судалгааг ажиллах хүчний судалгааны нэмэлт модуль болгон явуулснаар хүүхдийн хөдөлмөрийн талаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан нийтлэг тодорхойлолт, ойлголт, арга зүйг ашиглан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар өргөн хэмжээний мэдээлэл цуглуулж,

хүүхдийн эдийн засгийн идэвхи, хүүхдийн ажил, хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаарх мэдээллийн санг баяжуулсан юм.

“Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал” өрхийн панел судалгаа

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Германы эдийн засгийн судалгааны институт (DIW Берлин)-тэй хамтран өрхийн панел судалгааг 2012-2015 онд явуулах бөгөөд уг судалгааны онцлог нь судалгаанд сонгогдсон

өрхүүдийг солилгүйгээр тэдний аж байдалд гарсан өөрчлөлтийг 3 жилийн хугацаанд судлах юм. Судалгааны зорилго нь баруун 3 аймгийн өрхийн амьжиргаанд ган, үер, зуд болон таагүй үйл явдлууд хэрхэн нөлөөлж байгаа, ган, зуд болон бусад таагүй үйл явдлуудыг даван туулахын тулд өрхүүд ямар арга хэмжээ авдаг талаарх мэдээлэлтэй болох, анализ шинжилгээ хийх явдал бөгөөд энэхүү судалгааны үр дүн нь өрхүүд таагүй үйл явдлыг даван туулах чадавхийг хэрхэн сайжруулах талаар бодлого боловсруулагч нарт чухал мэдээлэл болох юм.

Энэхүү панел судалгааны эхний үе шат 2012 онд эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд уг судалгааны 2012 оны 9 сараас 2013 оны 8-р саруудын мэдээллийн баазад 127 нэгжийн 1016 өрхийн иж бүрдлийн болон логик шалгалтуудыг хийж, алдааг орон нутгаас тодруулан баазад тусгаж эцэслэсэн мэдээллийг ХБНГУ-ын Эдийн засгийн судалгааны институтэд хүлээлгэн өгсөн юм. Түүнчлэн “Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал” өрхийн панел судалгааны ахлагч, тоологч нарын сургалтын бэлтгэлийг хангаж, 12 ажилтанд 5 өдрийн сургалт зохион байгуулж, Говь-Алтай аймгийн Хөхморьт, Тайшир, Баян-Уул, Завхан аймгийн Сант маргад, Цэцэн-Уул, Улиастай сумдад 2 дахь шатны судалгааг амжилттай зохион байгуулж байна.

Жендерт суурилсан хүчирхийллийн судалгаа

Монгол Улсын “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай” хууль, уг хуулийг 2013-2016 онд хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги болон Статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр зэрэгт жендерийн статистикийн аргачлалыг

боловсруулж, мөрдөхөөр тусгасныг үндэслэн ҮСХ-ноос жендерийн мэдрэмжтэй статистикийн үзүүлэлтүүдийг боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Энэ ажлын хүрээнд дотоодын болон олон улсын зөвлөхүүдтэй хамтран жендерийн статистикийн үндсэн үзүүлэлтийг тодорхойлох, тооцох аргачлалыг олон улсын арга зүйд нийцүүлэн боловсруулах, албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг жендерийн мэдрэмжтэй болгох, мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлох, боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын жендерийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг 9 бүлэг 81 үзүүлэлттэй байхаар ойлголт, тодорхойлолт, тооцох аргачлалыг боловсрууллаа. Мөн жендерийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал,

ойлголт, тодорхойлолт бүхий 14 бүлэг, 240 үзүүлэлт бүхий гарын авлага боловсруулсан болно.


Жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны асуудлаар НҮБ-ын Хүн амын сан (НҮБХАС), Австралийн хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагийн төлөөлөгчидтэй хамтран түүврийн загвар, төсвийн төслийг дахин нягтлан боловсруулж, Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан хандивлагчдын уулзалтанд оролцон, жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны талаар нэгдсэн ойлголттой болсон юм.

Хүн ам, орон сууцны тооллого

Хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн тоо, мэдээллийг байнга шинэчлэх, хүн ам, өрхийн бүртгэлийг нэгдсэн байдлаар цэгцлэх, иргэний бүртгэлтийн өөрчлөлт болон нэн шаардлагатай бусад бүртгэлтэй холбогдох суурь мэдээллийн

санг бий болгох, хаягийн болон түүврийн сан үүсгэж, цаашдаа өрхөд суурилсан судалгаанд ашиглах зорилго бүхий хүн ам, орон сууцны завсрын тооллогыг Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасны дагуу явуулах бөгөөд энэхүү хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогыг явуулах үндсэн зарчмыг хүн бүрийг нэг бүрчлэн тоолох, тооллогын хугацаанд тооллогод хамрагдах нутаг дэвсгэрт нэгэн зэрэг тоолох, тооллогын мэдээлэл нийтлэг, иж бүрэн байх, тооллогыг тогтмол, давтамжтай явуулах зэргээр тодорхойлсон байна.

Хүн амын тархан суурьшил, эдийн засаг, нийгмийн төлөв байдал хором бүр хувьсан өөрчлөгдөж буй өнөө үед 10 жил тутам цуглуулсан тоо мэдээлэл цаг үеийн үнэ цэнээ алдаж хуучрах, тооллогын агуулга, чанарын шаардлагад нийцүүлэн тооллогыг аль болох зардал багатай зохион байгуулахаар төлөвлөж буй бөгөөд улс орны хүн амын тоо, тархан суурьшил, төлөв байдлын талаарх тооллогын мэдээлэл нь эдийн засаг нийгэм, хүн ам зүйн тухай мэдээлэлд үнэлгээ хийх, хүний хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулах, УБЕГ болон холбогдох байгууллагуудаас авсан мэдээллийн боловсруулалттай зэрэгцүүлэн дүн шинжилгээ хийх зэрэг зайлшгүй шаардлагыг тусгасан байх онцлогийг харгалзан 2015 оны завсрын тооллогын бэлтгэл ажлыг хангаж эхлээд байна.



Монгол Улсын хүн амын тооллогуудын дүн, хүн амын ердийн болон шилжих хөдөлгөөний 1935-2012 оны хоорондох мэдээллээр холбогдох аргачлал, онцлог тайлбар, танилцуулга бүхий лавлах бэлтгэж, Монгол Улсын хүн амын статистикийн 1900-2012 оны тоон үзүүлэлтэд 2000-2012 оны мэдээллийг нэмж оруулсан болно.

Хүн ам, орон сууцны тооллого, нэг удаагийн бүртгэлийн үр дүнгүүдээс хамгийн нийтлэг зэрэгцүүлж болох хүн амын тоо, нас, хүйс, бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин, өрх, ам бүлийн тоо зэрэг үзүүлэлтийг он тус бүрт нь хүснэгт, зургаар оруулав

1.3 Төрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоонд уялдсан салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулж, статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархаах шинэ технологи нэвтрүүлэх зорилтын хүрээнд:

Статистикийн үйл ажиллагааны технологийн үе шат бүрт шинэ технологи нэвтрүүлэх

Үндэсний Статистикийн Хорооны үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг нь олон улсын төдийгүй өөрийн улсад албан ёсны статистик мэдээллийн чанар, үнэн зөв бодит байдлыг хангаж, давхардлыг арилгах явдал юм. Статистик мэдээ, мэдээллийг сайжруулах, шинээр бий болгохдоо үр ашигтай бусад эх үүсвэрийг судалж ашиглах, салбарын статистикийг хөгжүүлэх, мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг зорилгоо болгон ажиллаж байна.

Статистикийн үйл ажиллагааны технологийн үе шат бүрт нийцтэй, өртөг зардал багатай, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, анхан шатны мэдээлэл цуглуулах болон мэдээллийн тархаалтад орчин үеийн зөөврийн тоног төхөөрөмж ашиглах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2011-2013 онд статистик мэдээллийн нэгдсэн систем буюу www.1212.mn, мал тооллогын онлайн систем, мэдээлэл цуглуулах технологид таблет ашиглах зэрэг технологийн дэвшлүүдийг нэвтрүүллээ. Тухайлбал, “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013”-ын мэдээлэл цуглуулахад орчин үеийн зөөврийн тоног төхөөрөмж болох таблет ашиглах боломжийг бүрэн хангаж, мэдээлэл цуглуулах программыг боловсруулж, 150 гаруй судлаачид сургалт хийж, судалгааг бүрэн авч дууссан бөгөөд ӨНЭЗС, АХС-ны анхан шатны мэдээлэл цуглуулахад таблет ашиглах боломжийг бүрэн хангаж, мэдээлэл цуглуулах программыг боловсруулав.

Орон нутгийн сервер компьютерүүдийн статистик мэдээллийг шивж оруулах, мэдээллийн санг үүсгэх, хадгалах, дамжуулах тохиргоог хийж, мэдээ тайлангийн боловсруулалтын программд байнга ашиглаж байна. Мэдээ, тайлангийн боловсруулалтын программын 30 хувийг онлайн горимд шилжүүллээ. Жилийн эцсийн мал тооллогыг интернэт болон төрийн сангийн сүлжээ ашиглан онлайнаар бүх сумаас шивэлт хийснээс гадна мэдээ тайлангийн программ (цалингийн судалгааны улирлын ЦС-1 мэдээний программ, хэвлэлийн тайлан, сонин, сэтгүүлийн жилийн ХТ-1, СС-1 мэдээний программ, авто, усан замын тээврийн тээвэрлэлтийн улирлын Т-1 мэдээний программ, шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгуулагуудын үйлчилгээний улирлын ШХИҮ-1 мэдээний программ, аж үйлдвэрийн салбарын сарын АҮ-1 мэдээний программ)-ыг интернэт ашиглан онлайнаар аймаг, нийслэл, дүүргээс шууд шивэлт хийх боломжтой болсон.


Статистикийн төв, орон нутгийн албадыг холбосон нэгдсэн дотоод сүлжээ байгуулах, нэгдсэн сүлжээний нууцлал, аюулгүй байдлыг хангах технологи нэвтрүүлэх зорилтын хүрээнд мэдээлэл технологийг хөгжүүлэх, нэгдсэн дотоод сүлжээ байгуулах төлөвлөгөөг боловсруулсны дагуу тоног

төхөөрөмжийн судалгаа, сонголт, сүлжээ байгуулах технологийн шийдлийг хийж, улмаар худалдан авалт, суурилуулалтын ажлыг эхлүүлсний зэрэгцээ сүлжээ болон системийн аюулгүй ажиллагааг хангах программ хангамжуудыг нэвтрүүлээ.

**Статистикийн салбарын
мэдээллийн нэгдсэн
сан, түүнийг үндэсний
бүртгэлийн мэдээллийн
сантай уялдуулах**

Статистик мэдээллийн нэгдсэн санг 1913-2013 оныг хамруулан он, улирал, сарын давтамжтай, улс, бүс, аймаг, сумын түвшний 38 салбарын 440 орчим статистик үзүүлэлтийг хамарсан байдлаар байгуулж www.1212.mn сайтаар хэрэглэгчдэд тархаж байна.

Ангилал, кодчиллын мэдээллийн санг бий болгох, www.code.gov.mn буюу Монгол Улсын ангилал кодчиллын мэдээллийн сантай уялдуулах чиглэлээр `common_database` буюу ерөнхий мэдээллийн санд ангилал, кодыг байрлуулан бүх мэдээллийн системд ашиглаж байна. Мөн статистикийн салбарт ашиглагдаж буй ангилал кодчиллын мэдээллийн санг статистик мэдээллийн сан www.1212.mn –д байрлуулан ашиглаж байна.



Тооллого, судалгааны нэгдсэн сан

Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан нэгдсэн санг удирдах болон хэрэглэгчид тархаах программ хангамжийг боловсруулах хүрээнд хөдөө аж ахуйн 2012 оны ээлжит тооллогын нэгжийн байршлыг Газарзүйн мэдээллийн сан (ГЗМС)-д бүрэн оруулж, тооллогын дүнг холбож дуусган Үндэсний Статистикийн Хорооны “Тооллогын мэдээллийн сан” дахь “Нэгдсэн дүн”-гийн хэсэгт орох 164 газрын зураг, хүснэгт, графикийг вебэд байршуулаад байна. Мянганы хөгжлийн зорилтууд болон “Ядуурлын зураглал-2011”-ын үр дүнг бүс, аймаг, сумын түвшний атласын вэб программыг боловсруулж, нийт 32 газрын зургийг тархааснаас гадна Хүн ам зүйн үндэсний атласын вэб программыг хийж байрлуулсан болно.

Тооллого, судалгааны анхдагч шатны мэдээллийг хэрэглэгчдэд нээлттэй болгосноор ӨНЭЗС, АХС, Хүүхэд хөгжил судалгаа, НАХ, Салбар хоорондын тэнцэл гэх мэт 25 төрлийн тооллого судалгааны задгай мэдээллийн сан, мета мэдээллийг монгол, англи хэлээр авах боломжтой болсон.

ҮСХ-ны Хүм, ам өрхийн бүртгэл, ААНБ-ын бизнес регистрийн мэдээллийн санг УБЕГ, ТЕГ-ийн мэдээллийн сантай уялдуулан шалгах, бүртгэлийн сангуудад шууд хандаж шаардлагатай тайлан мэдээг гаргаж авах, шалгах ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

Үндэсний Дата Төвд статистикийн мэдээллийн сангийн архив байрлуулсан бөгөөд ҮСХ-ны вэб сайт, е-мэйл хаягийг шилжүүлэн байршуулж, төрийн нэгдсэн сүлжээнд холбогдох бэлтгэл ажлыг хангасан болно.

Байгууллагын цахим хуудсыг хэрэглэгчдэд хүртээмжтэй, мэдээллийг ил тод, нээлттэй болгох ажлын хүрээнд байгууллагын цахим хуудсын бүтэц, дизайныг шинэчиллээ.

ҮСХ-ноос эрхлэн гаргадаг статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнүүдийг iOS болон Android төхөөрөмж ашиглан үзэх боломжтой Monstat аппликейшн болон статистик мэдээллийн нэгдсэн санг Android төхөөрөмж дээр харах боломжтой ezStat аппликейшнийг Мизорн ХХК-тай хамтран хийлээ.

ҮСХ-ны техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж, компьютер, принтер, хувилах машин, үйлдлийн систем, хэрэглээний программ хангамж, сүлжээ, телефон утас зэрэг нийт 200 дуудлагыг барагдуулсан байна. Мөн орон нутгийн статистикийн хэлтсүүдээс нийт 30 удаа гэмтэлтэй техник хэрэгсэл ирснийг засварлан, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Орон нутгийн интернет хурдыг нэмэгдүүлж 2-3 Мб хурдтай болгож нэмэгдүүлснээс гадна орон нутгийн албад болон олон улсын сургалт семинарт онлайн хурал хийх программ хангамжийг ердийн ажиллагаанд оруулж, 21 аймагтай тогтмол хуралдах боломжтой боллоо.

1.4 Чанарын удирдлагын механизмыг бүрдүүлэн нэвтрүүлж эхлэх зорилтын хүрээнд:

Чанарын удирдлага

Дэлхийн улс орнуудын албан ёсны статистикт чанарын тухай ойлголт чухлаар тавигдаж буй өнөө үед статистикийн салбарын хэмжээнд “Чанарын удирдлагын механизмыг бүрдүүлэн нэвтрүүлж эхлэх” зорилтыг дэвшүүлэн тавьсан билээ. НҮБ-ын Статистикийн Комиссын 44 дэх удаагийн чуулганаар “Чанар бол албан ёсны статистикийн зорилт мөн” гэж тунхагласныг гишүүн улс орнууд санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрсөн юм.

ҮСХ-ны даргын тушаалаар 2013 онд шинэчлэн байгуулагдсан “Статистикийн мэдээллийн чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх баг”-ийн үндсэн зорилго нь Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн хүрээнд статистикийн байгууллагын эрхлэх үйл ажиллагаа, статистикийн мэдээлэгчид, тэдгээрийн хоорондын хамтын ажиллагаа болон статистикийн мэдээллээр хэрэглэгчдийг хангах үйл явц бүрт тохирсон чанарын стандартыг боловсруулах, түүнийг хэвшүүлэн мөрдүүлэх замаар статистикийн салбарт чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Түүнчлэн статистикийн бүртгэлийг боловсронгуй болгон шинэчлэх; аргачлал, ангиллууд болон бусад үйл ажиллагааны стандартуудыг буй болгох; түүврийн арга зүйг оновчтой боловсруулж сайжруулах; улирлын нөлөөллийг тооцох чадварыг бэхжүүлэх; мэдээллийн чанарыг үнэлэх; стандарт асуулгын загварыг боловсруулах зэрэг чиглэлээр холбогдох зарчмуудыг тодорхойлон үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийг тогтоох зорилгоор статистикийн салбарын чанарын удирдлагын тогтолцооны суурь баримт бичиг болох “Монгол Улсын албан ёсны статистикийн чанарын бодлого” болон “Монгол Улсын албан ёсны статистикийн чанарын удирдлагын стандарт хэм хэмжээ”-г анх удаа боловсруулан батлууллаа.

Үндэсний статистикийн системийн зохицуулалт, статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үе шат, статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамарсан эдгээр баримт бичгүүд нь НҮБ-ын Статистикийн Комиссын 2012 оны 43-р чуулганаар баталсан “Чанарын баталгааны үндэсний тогтолцооны ерөнхий загвар” /NQAP/, Европын Холбооны статистикийн системийн статистикийн үйл ажиллагааны стандарт /CoP/ зэрэгт үндэслэсэн бөгөөд энэхүү чанарын бодлогын баримт бичгээр чанарын удирдлагын олон улсын ISO-9000 цуврал стандартын үндсэн зарчмуудыг баримтлан статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон болно. Тухайлбал, статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар нь хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн байх, бодитой байх, шуурхай байх, цаг хугацаандаа байх, ойлгомжтой байх, харьцуулах боломжтой байх, хүртээмжтэй байх, нийцтэй байх гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр баталгаажих юм.

Статистикийн байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог байнга сайжруулж, хүссэн үр дүнд хүргэх гол хэрэгслийн нэг нь статистикийн үзүүлэлтийн чанарын тайлан байдаг. Статистикийн үзүүлэлтийн чанарын

тайлан нь төлөвлөсөн зорилтыг хэрэгжүүлэх үе шат бүрийн болон статистикийн эцсийн бүтээгдэхүүний чанарын шаардлага хангалтыг тайлагнах бөгөөд цаашид чанарыг байнга сайжруулах арга зам, түүнийг хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг тусгадаг.

Чанарын тайлангийн зорилго нь хэрэглэгчид статистикийн байгууллагаас гаргасан тоо мэдээллийг хэрхэн цуглуулж, боловсруулж гаргадаг, мэдээллийн нууцлал хэрхэн хангагдсан, мэдээллийн чанар, үнэн бодит байдалд хэрхэн хяналт тавьж баталгаажуулдаг талаар нарийвчилсан мэдээлэл өгч статистикийн үйл ажиллагааг илүү тунгалаг, ил тод байлгах явдал юм. Чанарын баг албан ёсны статистикийн мэдээллийн чанарын тайланг хэрэглэгчид зориулан бичих зааврыг боловсрууллаа. Цаашид энэхүү зааврын дагуу мэдээ, тооллого, судалгаа бүрээр хэрэглэгчид зориулсан чанарын тайланг бэлтгэж нийтийн хүртээл болгож байх юм.

Сүүлийн жилүүдэд төрийн захиргааны байгууллагуудын статистикийн мэдээ, тайлан хариуцсан ажилтнуудад зориулан сургалт, семинарыг байнга зохион байгуулж ирлээ. 2013 онд яамд, агентлагуудын статистикийн мэдээ хариуцсан газар, хэлтсийн дарга, ажилтнуудад зориулан Хонгконгийн зөвлөх профессор Фредрик Хо 2013 оны 9-р сард сургалт зохион байгуулж, 11 яамны 29 удирдах ажилтан, мэргэжилтэн, 16 агентлагийн 20 мэргэжилтэн, нийт 49 хүнийг тус сургалтад хамруулав. Сургалтад хамрагдсанаар тухайн яам, агентлагийн мэдээ, тайлан хариуцсан ажилтнуудын чадавхи нэмэгдэж, улмаар тэдний гаргаж буй бүтээгдэхүүний чанар нэмэгдэхэд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

Аргачлал, арга зүй

“Статистикийн арга зүйг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох” ажлын хүрээнд 2013 онд төлөвлөсөн томоохон ажлын нэг нь статистикийн салбарт мөрдөгдөж буй аргачлал, арга зүй, зөвлөмжид мониторинг хийж, үнэлгээ дүгнэлт өгөх явдал байлаа.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулиар Үндэсний статистикийн хороо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг мэргэжлийн төвлөрсөн удирдлагаар хангаж, статистикийн үзүүлэлтүүд нь шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдмэл арга зүйтэй байх, олон улсын статистикийн стандарт, арга зүйтэй нийцсэн байх ёстой билээ.

Энэ хүрээнд салбарын статистикийн хамрах хүрээ, ойлголт, тодорхойлолт, томъёолол, тооцооны арга зүй, ойрын, дунд, урт хугацааны дүн шинжилгээний арга техникийг цогц байдлаар багтаасан аргачлалыг салбар тус бүрт тусгайлан боловсруулах шаардлагатай байдаг.

Улс орнууд нэгдсэн аргачлал, ангилал, стандарт дагаж мөрдсөнөөр тоо, мэдээллийн үр дүн бодитой байх, эдийн засаг, нийгмийн одоо ирээдүйн байдлыг тодорхойлох, таамаглах, олон улсын харьцуулалт хийх чухал ач холбогдолтой юм.


Статистикийн салбарт ҮСХ-ноос батлан гаргасан аргачлал, үзэл баримтлал, стандарт, ангилал, заавар, зөвлөмж, гарын авлагуудыг шүүж, салбараар ангилан, хүчингүй болсон аргачлалуудыг хасч, цаашид шинэчлэх шаардлагатай аргачлалуудад ҮСХ-ны газар, хэлтсүүдээс авсан саналуудыг тусгаж, мөрдөж буй аргачлал, арга зүйн зөвлөмжүүдэд үнэлгээ, мониторинг хийж дүнг 2013 оны 5 дугаар сард ҮСХ-ны Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох санал боловсруулж, цаашид шинээр боловсруулах болон шинэчлэн сайжруулах аргачлал, арга зүйн жагсаалтыг ҮСХ-ны даргын 2013 оны 69 тоот тушаалаар батлууллаа.

Статистикийн салбарт ҮСХ-ноос 1992-2013 онуудад батлагдсан 44 аргачлал, 35 үзэл баримтлал, 11 ангилал, стандарт, 36 арга зүйн зөвлөмж, гарын авлага, журам мөрдөгдөж байгаа бөгөөд ҮСХ-ны веб хуудсанд байрлуулсан болно.

Аргачлалыг салбараар нь ангилж үзвэл 12 нь үндэсний тооцоо, үнийн статистик, 3 нь хөгжлийн үзүүлэлт, 10 нь хүн ам, нийгмийн статистик, 5 нь хөдөлмөр, бүтээмжийн статистик, 14 нь эдийн засгийн салбарын статистикийн аргачлалууд байна.

Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн үзүүлэлтүүдийг боловсронгуй болгон сайжруулах зорилгоор 2013 онд 10 аргачлал, арга зүй, үзэл баримтлалыг шинээр болон шинэчлэн боловсруулан мөрдөж байна.

Шинээр болон шинэчлэн сайжруулсан аргачлал, үзэл баримтлал /2009-2013 он/



Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд тусгагдсан албан ёсны статистикийн мэдээллийн 48 үзүүлэлтээс 47 үзүүлэлтийг ҮСХ (МЭЗСГ, ХАНСГ, ХАОСТТ)-ноос гаргаж байгаа ба хөдөлмөрийн маргааны 1 үзүүлэлтийн мэдээллийг шинээр бий болгох, хүн ам, нийгэм, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн болон хүрээлэн байгаа орчны статистикийн 7 үзүүлэлтийг цаашид улам сайжруулж, мэдээлэл авах урсгал болон эх үүсвэрийг тодорхой болгох шаардлагатай байна.

Түүврийн арга зүй

Үндэсний хэмжээнд зохион байгуулж явуулах түүвэр судалгааны түүврийн арга зүйг сайжруулах, үнэлэлт, дүгнэлт өгөх, түүврийн дизайныг боловсруулах, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Түүврийн багаас тайлант хугацаанд дундаж цалингийн судалгааны түүврийн дизайн, худалдааны салбарын жилийн эцсийн мэдээний түүвэр, төрийн бус байгууллагын жилийн эцсийн мэдээний түүвэр, малын 2013 оны хагас жилийн тооллогын түүвэр судалгааны түүвэр, өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны түүврүүдийг хийж холбогдох удирдлага, зөвлөмж, аргачлалаар хангаж ажиллав.

“Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа”-ны түүврийн хэмжээ, дизайныг боловсруулах, түүврийг газар зүйн байршлаар хуваарилах, түүврийн хүрээг тодорхойлох, түүврийн нэгжийг тогтоох, түүврийн анхан шатны нэгж /ТАШН/-ийг түүвэрлэх техникийг сонгох зэрэгт арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

1.5 Салбарын ажилтнуудын мэргэжлийн болон менежментийн ур чадварыг дээшлүүлж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зорилтуудын хүрээнд:

Статистикийн салбарын хүний нөөц, түүний чадавхийг дээшлүүлэх

Үндэсний статистикийн салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сэлгэн ажиллуулах зорилт нь орчин үеийн удирдлага зохион байгуулалтын шинэ дэвшлийг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлагыг сайжруулах, чадварлаг, тогтвор суурьшилтай ажиллах боловсон хүчнийг төлөвшүүлэн мэргэшүүлэхэд чиглэгдэж байна. Статистикийн салбарт 2013 оны эцсийн байдлаар 297 албан хаагч ажил үүрэг гүйцэтгэж байгаа ба тайлант хугацаанд бид мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэхжүүлэх, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллалаа.

Үндэсний статистикийн салбарын хэмжээнд 2013 оны байдлаар 297 ажиллагчид, үүнээс ҮСХ-нд 117 хүн, орон нутгийн статистикийн газар, хэлтэст 180 хүн ажиллаж байна. Салбарын ажилтнуудын 37.2 хувь нь эрэгтэй, 62.8 хувь нь эмэгтэй ажилтнууд байна.

Салбарын ажилтнуудын тоо, хүйсээр, хувь




Нийт ажиллагчдын 63,4 хувь 10 хүртэлх жил ажиллаж байгаа бол 15.3 хувь нь 26-гаас дээш жил төрийн албанд ажиллаж байна. Салбарт ажиллагчдын 78.0 хувь нь бакалаврын боловсролтой, 19.6 хувь нь магистр, 2.4 хувь нь доктор байна.



2013 оны жилийн эцсийн байдлаар статистикийн салбарын ажилтнуудын 32.2 хувь нь статистикч-эдийн засагч, 29.5 хувь нь эдийн засагч, нягтлан бодогч, 4.7 хувь нь хүн ам зүйч, 33.6 хувь нь бусад (инженер, программист, математикч) мэргэжилтэй байна. 2013 оны жилийн эцсийн байдлаар статистикийн салбарын ажилтнуудын 32.2 хувь нь статистикч-эдийн засагч, 29.5 хувь нь эдийн засагч, нягтлан бодогч, 4.7 хувь нь хүн ам зүйч, 33.6 хувь нь бусад (инженер, программист, математикч) мэргэжилтэй байна.

**Статистикийн салбарын ажилтнуудын
мэргэжлийн байдал, хувь**



Тайлант хугацаанд мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, бэхжүүлэх зорилтын хүрээнд статистикийн салбарын “Хүний нөөцийн мэдээллийн систем”-ийг шинээр бий болгож, үүнд статистикийн салбарын үндсэн болон гэрээт ажилтан, сум баг, хорооны статистикийн асуудал хариуцсан ажилтан, Монгол Улсын хэмжээнд статистикийн мэргэжилтэй иргэд, уг мэргэжлээр суралцаж буй оюутан, статистикийн салбарт ажиллах хүсэлтэй иргэдийн судалгааг нийт 36 үзүүлэлтээр гаргаж нэгдсэн баяжилт хийсэн болно.

Салбарын хэмжээний төрийн захиргааны 230 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гаргуулан авч нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүллээ. Мөн их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн, шилжилт хөдөлгөөн, шинээр томилогдсон албан хаагчийн урьдчилсан мэдүүлэг зэргийг гаргуулан авч хянуулах, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг гаргуулан авах зэрэгт тухай бүрд нь холбогдох хууль журмыг танилцуулан хэрэгжүүлж ажиллалаа.

Авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд АТГ-аас зохион байгуулсан “Авлигын эсрэг хамтдаа аян”-д амжилттай оролцож, энэ аяны үеэр ЗГХЭГ, АТГ болон АНУ-ын Азийн сангаас хамтран зарласан төрийн байгууллагуудын дунд “Авлигаас ангид, сайн засаглалын туршлага шалгаруулах уралдаанд амжилттай дүн үзүүлсэн юм. Авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулан зурагт хуудас, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нийтийн албан хаагчдад зориулсан гарын авлага хэвлүүлэн салбарын ажилтнуудад болон хуулийн хамааралд хамрагдах албан тушаалтнуудад тарааж өгсөн болно. Статистикийн салбарын ажилтнууд нь хээл хахууль хүнд суртлаас ангид ангид төрийн үйлчилгээг иргэд, хэрэглэгчдэд байнга үзүүлж байдаг онцлогтой билээ.

Тайлант хугацаанд Үндэсний статистикийн хорооны 109 төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гаргаж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн ба төрийн албаны нөөцөөс шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн 6 ажилтны ажлын байрны захиалга өгч Төрийн албаны зөвлөлөөс тогтоол гаргаснаар уг ажлын байранд томилох, тангараг өргүүлэх ажлыг зохион байгууллаа. Мөн энэ хугацаанд шинээр 55 иргэнтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан тодорхой ажил үүргийг гүйцэтгүүлсэн байна. Нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн өөрчлөлт хөдөлгөөнтэй холбогдуулан ирүүлсэн 32 иргэний томилогдох, 24 иргэний чөлөөлөгдөх хүсэлт, анкет материалыг судлан удирдлагаас санал авах, шийдвэрийн хариу хүргүүлэх ажлын зохион байгуулжээ.

Төрийн захиргааны албан хаагчдын үйл ажиллагаа үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэн албан тушаалын зэрэг дэв олгуулахаар Төрийн албаны зөвлөлөөр дамжуулан Ерөнхийлөгчийн тамгын газарт танилцуулга материалыг тухай бүр хүргүүлэн зэрэг дэвийг олгуулсны зэрэгцээ төрийн албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг холбогдох хууль журмын дагуу тухайн бүр шийдвэрлэн олгож байна.

Сум, баг хорооны түвшинд статистикийн асуудал хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах, аргачлал, арга зүйн гарын авлагаар хангах ажлын хүрээнд нийт 20 аймгийн 1580 багийн Засаг дарга нарт тусгай хөтөлбөрийн дагуу чадавхи бэхжүүлэх сургалтыг зохион байгууллаа. Энэ сургалтаар багийн Засаг дарга нар статистикийн чиглэлийн хууль тогтоомжийг судалж, албан ёсны тооллого судалгаа, статистикийн анхан

шатны мэдээллийг гаргах аргачлалын талаар судалж, мэдлэг дадлага олж авснаас гадна тэднийг гарын авлага бусад ажлын хэрэгцээний ном товхимлоор хангасан юм. Энэ сургалтын үр өгөөжийг багийн Засаг дарга нар өндрөөр үнэлснээс гадна энэ сургалтыг цаашид тодорхой, тогтмол хугацаагаар хийж байх нь зайлшгүй хэрэгцээтэй гэж үзсэн байна.



Баг хорооны статистикийн мэдээ тайлан хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт

Статистикийн төв, орон нутгийн ажилтнуудад зориулсан 3 шатны сургалтыг МУИС-ийн ЭЗС, ХААИС-ийн багш нартай хамтран зохион байгуулж уг сургалтад ҮСХ-ноос 15, нийслэл, дүүргээс 18, аймгаас - 7, гадны байгууллагаас (ЦЕГ, ГЕГ, ТЕГ зэрэг) 8 хүн нийт 48 ажилтан оролцож амжилттай суралцан сертификат авсан байна. Мөн САНТИС төвийн англи хэлний сургалтанд нэлээд ажилтнуудыг хамруулж үргэлжлүүлэн суралцуулж байна.

ҮСХ-нд шинээр ажилд орсон (24) ажилтнуудад “Байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, хууль, журам, ангилал, албан хэрэг хөтлөлт” сэдвээр сургалт зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын хариуцлагын талаар танилцуулсан. ХААИС-ийн оюутнуудад “Байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, хууль, журам, ангилал, албан хэрэг хөтлөлт” сэдвээр сургалт зохион байгуулсан болно.

Статистикийн салбарын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнийг 2013 оны 7-р сард Увс аймагт амжилттай зохион байгууллаа. Энэхүү зөвлөгөөнөөр статистикийн салбарын өнөөгийн байдал, орон нутгийн статистикийн байгууллагын үүрэг, зорилт, ажлын уялдаа холбоо зэрэг олон тулгамдсан асуудлуудыг хөндөн хэлэлцэж, цаашид анхаарч хэрэгжүүлэх 25 зорилтыг дэвшүүлсэн. Зөвлөгөөний үеэр орон нутгийн газар, хэлтсийн дарга нар болон ҮСХ-ны удирдлагууд Увс аймгийн статистикийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцан харилцан туршлага солилцлоо.



Статистикийн салбарын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнийг 2013 оны 7-р сарын 15-26-нд Увс аймагт зохион байгуулав.

Их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж статистик, эдийн засаг, хүн ам зүйн болон мэдээллийн технологи, гадаад харилцаа зэрэг мэргэжлийн чиглэлээр суралцаж байгаа 43 оюутныг хүлээн авч дадлагажуулах ажлыг зохион байгууллаа.

Статистикийн салбарын нэр хүндийг өсгөх, шагналын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор “Статистикийн салбарын шагналын журам”-ыг

шинэчлэн боловсруулж холбогдох нэгжүүдэд хүргүүлэн мөрдөн ажиллаж байна. Бүртгэл, статистик, эдийн засгийн салбарт хамтран ажилладаг бусад эдийн засгийн болон орон нутгийн байгууллагуудаас салбарын шагналаар шагнуулахаар тодорхойлолтоо ирүүлсэн иргэдийн анкет материалыг судлан, санал авч Салбарын дээд шагнал болох “Бүртгэл статистикийн ажилтан цол тэмдэг”-ээр 24 хүн, Үндэсний статистикийн хорооны жуух бичгээр 11 хүн шагнагдсан байна.

“Статистикийн байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийг шинээр баталж салбарын хэмжээнд мөрдөж байна.

ҮСХ-ны удирдлага, орон нутгийн статистикийн хэлтсүүдээс “Статистик хөгжилд хөтлөгч хүч” сэдэвт хичээлийг анх удаа 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр нийслэл, 21 аймгийн Ерөнхий боловсролын 49 сургуулийн ахлах ангийн 3500 гаруй сурагчдыг хамруулан заалаа.



Ажилтнуудыг гадаад орнуудын статистикийн байгууллагуудаас туршлага судлах танилцах айлчлал, гадаад, дотоодын уулзалт, семинар, арга хэмжээнд хамруулах, урт, богино хугацааны мэргэшүүлэх сургалтад явуулах, мөн гадаад хэлний мэдлэгээ сайжруулах, төрийн албан хаагчийн хувьд мэргэшиж төлөвших боломжийг олгоход чиглэсэн сургалтад хамруулах чиглэлээр багагүй ажлуудыг хийжээ. Статистикийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, урт хугацааны сургалтад хамруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авсны үр дүнд Энэтхэгийн статистикийн институтийн мэргэжил дээшлүүлэх урт хугацааны сургалтад тус хорооны хоёр ажилтан амжилттай суралцаж байна. Салбарын хэмжээнд 2013 онд давхардсан тоогоор нийт 151 албан хаагч 61 удаагийн гадаад сургалт, семинар, арга хэмжээнд зохион байгуулагч болон олон улсын байгууллага, Монстат төслийн санхүүжилтын дэмжлэгтэйгээр оролцсон байна.

*Монгол Улсын статистикийн
салбарын удирдлага, зохион
байгуулалт, гадаад харилцаа, төсөв,
2014 оны зорилго, зорилт*

**Статистикийн салбарын
удирдлага, зохион
байгуулалт**

Үндэсний статистикийн салбарын 2012 оны үйл ажиллагааны тайланг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2013 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, тус салбарын 2012 оны үйл ажиллагааны

дүнг “сайн” үнэлгээтэйгээр дүгнэсэн билээ.

УИХ-ын даргын санаачилгаар ҮСХ-ноос УИХ-ын харьяа байгууллагуудын удирдлагуудын уулзалтыг анх удаа зохион байгуулж уг уулзалтад УИХ-ын даргын ажлын алба, УИХ-ын Тамгын газар, Үндэсний аудитын газар, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Сонгуулийн ерөнхий хороо, Монгол банк, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газруудын удирдлагууд оролцсон ба УИХ-ын харьяа байгууллагууд өөрсдийн тулгамдаж байгаа нийтлэг асуудлуудаа хамтран шийдвэрлэх талаар санал солилцон статистикийн салбарын үйл ажиллагааны талаар Хорооны дарга танилцуулга хийж тодорхой мэдээлэл өгсний зэрэгцээ эдгээр байгууллагуудын хамтран ажиллах бүлгийн даргаар Хорооны дарга С.Мэндсайхан томилогдсон болно.

Монгол Улсын УИХ-ын дарга З.Энхболд 12-р сарын дундуур манай байгууллагад хүрэлцэн ирж, бидний ажил байдалтай танилцан, ажилтнуудын төлөөлөлтэй уулзаж, харилцан санал солилцсоны дүнд тус Хороонд тулгамдаж байгаа тодорхой асуудлуудыг, тухайлбал, төрийн албаны салбар зөвлөл байгуулах, суманд статистикийн орон тооны ажилтантай болох, мэдээллийн нэгдсэн сантай байх, салбарын үйл ажиллагааны үр дүнд бий болсон бодит хэмнэлтийг ашиглах, салбарын 90 жилийн ой ирэх онд тохиож байгаатай холбогдуулан статистикийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар УИХ-аас тусгайлсан тогтоол гаргуулах зэрэг 5 багц асуудлыг шийдвэрлэхэд тодорхой санаачилга гаргасан юм.

Үндэсний Статистикийн хорооноос 2013 онд статистикийн мэдээллийн үйлчилгээнд дэвшилтэт технологийг ашиглан мэдээллийн үйлчилгээг өргөжүүлэх, хэрэглэгчийн статистикийн боловсролыг дээшлүүлэх сургалт, хэрэглэгч-олон нийттэй харилцах, сурталчилгааны ажлыг шинэ шатанд гаргах зорилттой ажиллалаа.

Бид 2013 оныг “Статистикийн хэрэглэгчдийг эрэлт хэрэгцээнд нь нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах шинэчлэлийн жил” болгох үндсэн зорилгоо ханган биелүүлэхийн тулд Мэдээллээр үйлчлэх төвийг ТЗУГ-

ын дэргэд “Мэдээлэл, сургалт, сурталчилгааны төв” болгон шинэчлэн зохион байгуулж, улмаар мэдээллийн үйлчилгээ, сурталчилгааны ажлыг өргөжүүлэн, тооллого судалгааны үр дүнг олон нийтэд өргөн сурталчилж ажиллав.

Мэдээлэл, сургалт, сурталчилгааны төв нь байнга хэвлэн тархаадаг үндсэн бүтээгдэхүүнүүдээс гадна энэ онд “Монголулс 2012” нугалбар, “Статистикийн өврийн дэвтэр 2012”-ийг богино хугацаанд гаргаж хэрэглэгчдэд хүргэсэн нь шинэлэг ажил болсон юм. Мөн “Статистикийн цагаан толгой”, “ХАА-н 2011 оны улсын анхдугаар тооллогын нэгдсэн болон үндсэн үр дүн”, “Хүүхэд хөгжил 2010 судалгаа”, “Нас, хүйсийн бүтцийн шинжилгээ”, “Хүн амын хэтийн 2010-2040 оны шинэчилсэн тооцоо” сэдэвчилсэн судалгааны ном, сурталчилгааны материал зэрэг 90 мянга гаруй ном, бүтээгдэхүүн, 200 гаруй хувь CD -ийг хэрэглэгчдэд хүргэж, цахим хэлбэрээр тархааж ажиллав.

Энэ онд давхардсан тоогоор 1212 лавлах утсанд 2508, Information@nso.mn, statistic@nso.mn хаягаар 341, өөрийн биеэр ирж үйлчлүүлсэн 923, албан бичиг болон энгийн утсаа 351 хэрэглэгч, нийт 4123 хэрэглэгчдэд мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Хэрэглэгчийн бүртгэлийн программд 1733 хэрэглэгч, www.nso.mn сайтын бүртгэлийн хэсэгт 2260 хэрэглэгч бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн нийт 3993 хэрэглэгчдийн e-мэйл хаягаар статистикийн мэдээллийг инфографик дүрслэлтэйгээр, шинэлэг байдлаар хүргүүлж байна. www.1212.mn сайтад 113270, www.nso.mn сайтад 90102, нийт 203372 хэрэглэгч хандаж мэдээллийн үйлчилгээ авсан байна. www.nso.mn сайт-ны шуурхай мэдээ буланд сар бүрийн мэдээг тархаалтын хуваариас өмнө шуурхай оруулж, нийт 43 хүснэгт, 248 графикаар дүрсэлсэн мэдээ байршуулж байна.

Хэрэглэгчийн бүртгэлийн санд бүртгэгдсэн хэрэглэгчийн e-мэйл хаягаар Sendblaster программ ашиглан хэрэглэгчдэд мэдээлэл тогтмол явуулж байна. Үүнд: Сар бүрийн мэдээ, танилцуулга, 7 хоног тутам махны үнэ, улирлын ДНБ-ний мэдээлэл, цаг үеийн мэдээ /Хөдөө аж ахуйн тооллогын дүн, Хүн ам 2.9 саяд хүрэх тухай мэдээлэл, 2012 оны эмхэтгэлийн CD худалдаанд гарсан тухай, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013 зэрэг/. Энэ оны 10-р сараас эхлэн infografic хэлбэрээр зураг, дүрс бүхий мэдээллийг цахим хаягаар илгээж, вэб хуудсандаа байрлуулж эхэлсэн нь хэрэглэгчид болон хэвлэл мэдээллийн ажилтнуудын сонирхлыг татах боллоо.

Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг танилцуулах “ICT EXPO 2013” үзэсгэлэн яармагт анх удаа оролцож статистикийн салбарын мэдээлэл, технологийн хөгжлийг харуулсан үзэсгэлэн гаргасны зэрэгцээ Monstat, Ezstat, www.1212.mn, www.nso.mn цахим хуудсууд болон ҮСХ-ноос эрхлэн гаргадаг статистикийн мэдээлэл, тооллого, судалгааны үр

дүнг сурталчлах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулав.

ҮСХ-ны номын санд "BOLBEC"ХХК-аас худалдан авсан Lib4U PC Version 1.2 программыг 2013 оны 2 сарын 1-нээс ашиглаж номын сангийн номыг электрон каталогит оруулах ажил хийгдэж эхэлсэн ба тус программд нийт 766 төрлийн 1983 номыг бүртгэж, нүүр хуудсыг скайнердэж, ном тус бүрт зураасан код хэвлэн номын фондод байрлуулсан болно.



ҮСХ-ны номын сан

Номын сангийн тохижилтын ажил хийгдэж комиссын актаар хүлээн авч, хэрэглэгчийн 2 компьютерийг сүлжээнд холбуулснаар номын сангаар үйлчлүүлж буй хэрэглэгчдэд номын каталогийг танилцуулах, 1212.mn, www.nso.mn-ыг ашиглах зааврыг танилцуулах, статистикийн мэдээллийг авах зааврыг өгч, ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг борлуулах, сурталчлан таниулах, хэрэгцээт мэдээллийг хувиран өгөх ажлууд хийгдэж байна.

Тайлант хугацаанд Үндэсний статистикийн хорооны Архивын журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан ба байгууллагын дотоод архивын цахим сан үүсгэх ажлын хүрээнд Архивын ерөнхий газраас гаргасан ORG-AMS архивын программын шинэчлэгдсэн хувилбарыг авч суулган, 1989 оноос хойшхи нийт 224 нэгжийг зурган файл болгох ажил хийгдэж байна.

Статистикийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, 1-р сард болсон эхний зөвлөгөөний үеэр нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн 2012 оны ажлыг үнэлж дүгнэсэн бол хоёр дахь сургалт, зөвлөгөөнийг 2013 оны 7-р сард Увс аймагт статистикийн салбарын өнөөгийн байдал, орон нутгийн статистикийн байгууллагын үүрэг, зорилт, ажлын уялдаа холбоо зэрэг асуудлуудаар зохион байгуулж, 25 зорилт дэвшүүлэн холбогдох арга хэмжээ авч ажиллалаа.

ҮСХ-ны 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хорооны даргын нэрэмжит үзлэгийг 4 аймагт зохион байгуулахаар тусгасан ба Дорнод, Ховд аймгуудад статистикийн үйл ажиллагааны цогц үнэлгээг хийлээ.

Эдгээр 2 аймагт “Статистикийн тухай” хуулийн хэрэгжилт, статистикийн салбарын үйл ажиллагаа, анхан шатны нэгж /аймаг, сум, баг/ дэх албан ёсны статистикийн мэдээллийн үнэн зөв, бодит байдалд үнэлгээ хийж тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх зорилготойгоор ҮСХ-ны даргаар ахлуулсан ажлын хэсэг ажилласан юм.

**Гадаад харилцаа,
хамтын ажиллагааг
бэхжүүлэх**

Монгол Улс НҮБ-ын Статистикийн комисс (НҮБСК)-ын албан ёсны 24 гишүүн орноос Азийн бүсийг төлөөлөн 2011 онд анх удаа НҮБ-ын Статистикийн комиссын гишүүн орноор сонгогдож, 2012 оноос сонгуульт ажлаа гүйцэтгэж эхэлснээс хойш олон улсын

статистикийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгарч буй олон асуудлуудыг шийдвэрлэхэд амжилттай оролцож, өөрийн орны саналыг албан ёсны шийдвэрүүдэд гишүүн орны хувьд тусгуулах боллоо.

НҮБСК-ын ээлжит 44-р чуулган 2013 онд болж, тус чуулганы болон түүний салбар хуралдаанд нийт 135 улсын үндэсний статистикийн байгууллага, 47 олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцсон бөгөөд нийт 15 асуудал хэлэлцэгдэж, 17 асуудал танилцуулагдсан байна. Тус чуулганд ҮСХ-ны дарга С.Мэндсайхан тэргүүтэй төлөөлөгчид оролцож, чуулганы үеэр хэлэлцэх 9 асуудал, мэдээлэх 7 асуудлаар өөрийн байр суурийг илэрхийлснээс гадна олон болон хоёр талт уулзалтуудыг амжилттай зохион байгуулж, статистикийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгарч буй асуудлуудаар санал зөвлөмж, туршлага хуваалцах замаар олон улсын статистикийн нийгэмлэг дэх байр сууриа бэхжүүлж, хоёр талт хамтын ажиллагааны шинэ боломжуудыг нээлээ.

Олон талт хамтын ажиллагаа

ҮСХ нь албан ёсны статистикийн салбарт олсон ололт, хамтын ажиллагааны туршлагыг бататгах үүднээс бүс нутгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ хүрээнд НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн засаг, нийгмийн Комисс (АНДЭЗНК)-ийн Статистикийн хороотой нягт хамтран ажилладаг ба тус Хорооны төлөөлөл НҮБ-ын АНДЭЗНК-ийн Статистикийн Хорооны Товчооны дэд дарга, Эдийн засаг болон нийгмийн статистикийн техникийн зөвлөх баг, мөн Хөгжлийн бэрхшээлийн статистикийн Вашингтон групп-д сонгогдон ажиллаж байна.

Монгол Улс, Австралийн хамтран санаачилсан “Байгалийн нөөцөд суурилсан эдийн засгийн статистикийн Улаанбаатар хотын групп”-ийн хүрээнд удирдах зөвлөл болон шинжээчдийн уулзалтуудыг зохион байгуулж, уул уурхайн салбарын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нийт 214 статистик үзүүлэлтийг тодорхойллоо.

Америк, Ази, Номхон далайн үндэсний тооллого, статистикийн байгууллагын дарга нарын нийгэмлэгтэй хамтран Хүн амын тооллогын 26 дугаар бага хурлыг 2013 оны 6-р сард Улаанбаатар хотод амжилттай

зохион байгуулж, 12 орон, олон улсын судалгааны 2 байгууллагын нийт 24 төлөөлөгч оролцов. Энэ хурлаар ХАОСТТовчооны дарга А.Амарбал Америк, Ази, Номхон далайн орнуудын статистикийн байгууллагын хүн амын тооллогын асуудал хариуцсан дарга нарын нийгэмлэгийн дэд даргын сонгуульт үүрэг хүлээсэн нь манай байгууллагын олон улсын түвшинд үнэлэгдэж байгаагийн илрэл болсон юм.



Америк, Ази, Номхон далайн үндэсний тооллого, статистикийн байгууллагын дарга нарын нийгэмлэгтэй хамтран Хүн амын тооллогын 26 дугаар бага хурлыг 2013 оны 6-р сард зохион байгуулав.

2013 оны 03-р сарын 20-ний өдөр ҮСХ-ноос гаргасан албан хүсэлтийн дагуу НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (НҮБЕЭЗК)-оос Монгол Улсын үндэсний статистикийн системд цогц үнэлгээ хийхээр НҮБЕЭЗК-ын Статистикийн хэлтэс, НҮБ-ын АНДЭЗНК, Европын Чөлөөт Худалдааны Ассоциаци, Норвегийн Статистикийн газрын төлөөлөгчдөөс бүрдсэн үнэлгээний баг томилогдож, 2013 оны 9-р сарын 30-аас 10-р сарын 04-ний өдрүүдэд Монгол Улсын ҮСХ-нд ажилласан бөгөөд ирэх онд үнэлгээний багийнхан эцсийн үр дүнгээ танилцуулах болно.



ҮСХ-ны үйл ажиллагаанд Статистикийн Олон улсын цогц үнэлгээний баг /ЕЧХА, НҮБАНДЭЗНК, НҮБЕЭЗК/ 2013.09.30-10.04-нд эхний үнэлгээ хийлээ.

Монстат төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 4 жилийн хугацаа өнгөрч байгаа ба 2013 онд Дестатистаас 7 удаагийн зөвлөх үйлчилгээ үзүүлж, 6 удаагийн танилцах айлчлалд ҮСХ-ны 24 ажилтан оролцов. Түүнчлэн Монстат төслөөс санхүүжүүлэн олон улсын 9 хурал, сургалт, айлчлалд 15 удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг оролцуулжээ. Монстат төслийн хүрээнд үндэсний статистикийн бодлого, эрх зүй, институц, бүтэц удирдлагын бүтэц, тогтолцоог сайжруулах, статистикийн дэд бүтцийг бэхжүүлэх, статистикийн үйл ажиллагааны сэдэвчилсэн хөтөлбөр, арга зүй, аргачлалын асуудлаар олон ажил хийж гүйцэтгэсэн ба 2014 онд уг төслийн үр дүнг түгээх олон улсын хурал Улаанбаатар хотод зохион байгуулагдах юм.

Хоёр талт хамтын ажиллагаа

Монгол Улсын ҮСХ өнөөгийн байдлаар нийт 9 улсын статистикийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж байгаа ба 2013 онд БНТУ болон БНСУ-ын статистикийн байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээг шинэчилсэн юм.

БНТУ-ын Статистикийн институттэй (ТСИ) байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хүн ам, нийгмийн статистикийн чиглэлээр түлхүү хамтран ажиллаж, эдийн засгийн статистик, мэдээллийн технологи, ҮСХ-ны сургалтын төвийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр харилцан туршлага солилцлоо. ҮСХ-ноос 2013 онд дөрвөн танилцах айлчлалын хүрээнд ҮСХ-ноос 11 хүн томилолтоор ажиллаж, дөрвөн зөвлөх үйлчилгээний хүрээнд Туркийн Статистикийн институтээс 8 ажилтан ирж, харилцан туршлага солилцож ажиллав. ҮСХ-ны даргын урилгаар ТСИ-ийн ерөнхийлөгч Бирол Эйдемир тэргүүтэй төлөөлөгчид тус хороонд 2013 оны 7 сард албан ёсны айлчлал хийж, тус 2 байгууллагын хоорондох Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилт, МУ-ын үндэсний статистикийн систем, Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагаатай танилцсан юм.

БНСУ-ын Даэжеон хотод 2013 оны 5 сард Монгол Улсын ҮСХ болон БНСУ-ын Статистикийн газар хоорондын хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд тус Хорооны дэд дарга Б.Эрдэнэсүрэн, БНСУ-ын Статистикийн газрын дарга ноён П.Хьёнсүү нар статистикийн салбарт хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав. Шинэчлэн байгуулсан санамж бичгийн хүрээнд талууд мэдээллийн технологи, хүний нөөцийг бэхжүүлэх, эдийн засаг, нийгмийн салбарын статистикийн туршлагаас харилцан солилцох чиглэлд үргэлжлүүлэн хамтран ажиллахаар болсон юм. Статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn-ийн англи хувилбар, аймгийн түвшинд гардаг үзүүлэлтийг газрын зургаар харах системийг БНСУ-ын Нуримсофт компанитай ҮСХ хамтран боловсруулав.

Монголын Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагаа сайжирч байгааг олон улсын бие даасан байгууллагуудаас гаргасан мэдээллийн эх үүсвэрээс харагдаж байна. Тухайлбал, улс орнуудын статистикийн байгууллагын чадавхийг жил бүр үнэлдэг Дэлхийн банкны үнэлгээгээр 2013 онд Монголын үндэсний статистикийн чадавхийн үнэлгээний ерөнхий

дундаж оноо 83, статистикийн аргачлалын оноо 70, мэдээллийн эх үүсвэрийн оноо 100 байгаа нь дэлхийн дундаж түвшингээс дээгүүр байна.

Дэлхийн банкны статистикийн чадавхийг үнэлэх үнэлгээний үзүүлэлтүүд

Он	Статистикийн аргачлал		Мэдээллийн эх үүсвэр		Мэдээллийн давтамж, хугацаа		Ерөнхий дундаж	
	Монгол	Дэлхийн дундаж	Монгол	Дэлхийн дундаж	Монгол	Дэлхийн дундаж	Монгол	Дэлхийн дундаж
2005	70	56	80	64	87	81	79	67
2010	60	57	80	67	83	83	74	69
2011	70	58	80	67	83	83	78	69
2012	70	57	80	66	83	83	78	69
2013	70	58	100	65	80	82	83	68

Эх үүсвэр: <http://go.worldbank.org/UI0WGV6KW0>

Төсөв, санхүү

Үндэсний статистикийн хорооны 2013 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсөв 5164.8 сая төгрөг, хөрөнгө оруулалт 231.0 сая төгрөг, ХАОСТТ-нд 932.9 сая төгрөг, өөрийн орлогоос 14,4 сая төгрөг буюу нийт 6343.1 сая төгрөгөөр батлагдсан. Тус хорооны 2013 оны жилийн төсвийн зарлагын гүйцэтгэлийн хувьд урсгал зардалд 3517.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 183.9 сая төгрөгийг батлагдсан төсвийн дагуу зарцууллаа. Байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос орсон 10.9 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан болно.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 онд 231.0 сая төгрөгийн санхүүжилт авахаас 183.9 сая төгрөг авч 45 нэр төрлийн 183.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авч бүртгэлд тусган, 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт DELL i5 компьютерийг тус бүр 1-ийг хуваарилж хүргүүлсэн.

Статистикийн салбарын төсөв, санхүүгийн байдал, сүүлийн 3 жилээр, сая,төг

	2011	2012	2013
Урсгал санхүүжилт	4 682.5	4 956.2	8 915.5
Хөрөнгө оруулалт	89.1	336.0	183.8

ҮСХ, ХАОСТ-ын товчоо болон НҮБ-ын Хүн амын сангийн төслийн санхүүгийн баримтанд аудит хийлгэж, зөрчилгүй дүгнэлттэй гарлаа.

Бид улсын төсвийн болон төслийн хөрөнгийг хэмнэж, өөрсдийн дотоод нөөц бололцоогоо дайчлан (тухайлбал, хэвлэлийн цехийн үйл ажиллагааны орлого) ажилласнаар байгууллагын ажиллах дотоод орчинг сайжруулж,

вестбюль, 2 давхрын уулзалтын өрөөг тохижуулах, ҮСХ-ны ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор биеийн тамирын танхимыг тохижуулах, өрөөнүүдэд шинэ тавилга, эд хогшил, ус буцалгагч, суурин утасны аппарат, принтер, компьютер зэргээр ханган албан хаагчдын ажиллах нөхцлийг зохих түвшинд сайжруулан ажилласан юм.

Билгийн улирлын хаврын тэргүүн сар, Ахмадын өдрийг тохиолдуулан нийт 104 ахмад ажилтнуудаа 2 удаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсны зэрэгцээ олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хорооны албан хаагчдын 104 хүүхдэд хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулав.

Салбарын ажилтнуудын чөлөөт цаг, амралтыг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг болгон “Orchlon club”-тэй 3 сарын гэрээ байгуулан бодибилдинг, аква фитнес, бассейн, аэробик, иог, саун, ширээний теннис, сагсан бөмбөг зэрэг спортын цогц үйлчилгээнд төлбөрийн 30-50 хувийн хөнгөлөлт үзүүлэн хамрууллаа.

Орон нутгийн албан хаагчдын ажлын нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад дэмжлэг болгож нийт 121.0 сая төгрөгийг орон нутгийн статистикийн хэлтсүүдэд шилжүүлжээ.

Статистикийн хөгжлийн сангаас шинээр төрсөн 10 хүүхдэд 5.0 сая төгрөг, 11 хүнд 25,0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон ба 2013 онд гэр хороололд амьдран суудаг 12 ажилтанд 2160.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлэв.

УИХ-ын харьяа байгууллагуудын дунд жил бүр уламжлал болон зохиогддог шилжин явах цомын төлөөх 4 дэх удаагийн ээлжит тэмцээнийг Үндэсний Статистикийн Хороо “УИХ-ын ЦОМ” нэртэйгээр 2013 оны 5-р сард спортын 7 төрлөөр зохион байгууллаа. Энэ удаагийн тэмцээний нийлбэр дүнгээр Монгол Банкны хамт олон тэргүүлж, шилжин явах цомын эзэн боллоо. 2 дугаар байрыг УИХ-ын Тамгын Газрын баг тамирчид, 3 дугаар байрыг манай хамт олон эзэлж, өмнөх жилийн амжилтаа нэг байраар урагш ахиулсан юм.

**Үндэсний статистикийн
салбарын 2014 оны
зорилго, зорилт**

Үндэсний статистикийн хороо нь “Статистикийн тухай” хуулийн дагуу заагдсан тооллого, судалгааг чанартай явуулах, статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, Монстат төслийн үйл ажиллагааг амжилттай дуусгах, салбарын түүхт ойгоо өндөр бүтээлээр угтахаар 2014 оныг **“Орон нутгийн статистикийн албадын чадавхийг бэхжүүлж, анхдагч мэдээллийн чанарт ахиц дэвшил гаргах”** үндсэн зорилгыг дэвшүүлж байна. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Нэг. Улсын бүртгэлд суурилсан хүн ам, өрх, бизнес регистрийн санг шинэчлэн байгуулж, төрийн нэгдсэн сүлжээнд холбох, статистикийн салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулж, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархаах үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг өргөн ашиглах;

Хоёр. Орон нутгийн хэрэгцээнд суурилсан статистикийн үзүүлэлтийн хүрээг тодорхойлж, арга зүйг боловсруулж, хэрэгжүүлэх;

Гурав. Статистикийн боловсрол, хэрэглээний үр өгөөжийг дээшлүүлэх;

Дөрөв. Салбарын ажиллагчдын цалин, урамшууллын оновчтой системийг бий болгож, нийгмийн асуудалд бодитой дэмжлэг үзүүлэх;

Тав. Статистикийн албаны 90 жилийн ойн хүрээнд Монгол улсын статистикийн хөгжлийн түүхэн замнал, хүрсэн түвшин, олон улсад эзлэх байр суурь, оролцоог илтгэсэн бүтээлч ажил өрнүүлэх.

Хавсралт №1.

ҮСХ-ны Даргын Зөвлөлийн хурлаар шинээр болон шинэчлэн батлагдсан аргачлал, үзэл баримтлал

Д/д	Аргачлал, үзэл баримтлал	Тушаалын дугаар, огноо
1	2013 онд мөрдөх "Хүн амын амьжиргааны доод түвшин"-ийн тооцоо	ҮСХ-ны даргын 2013 оны 4-р сарын 9-ний өдрийн 01/52 тоот тушаал
2	"Нийгмийн үзүүлэлтийн судалгаа-2013"-ны үзэл баримтлал	ҮСХ-ны даргын 2013 оны 7-р сарын 31-ний өдрийн 01/92 тоот тушаал
3	Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлал, үзэл баримтлал, маягт, заавар	ҮСХ-ны дарга, НХХ-ийн сайдын 2013 оны хамтарсан тушаал
4	Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлого тооцох аргачлал	ҮСХ-ны даргын 2013 оны 11-р сарын 26-ны өдрийн 01/134 тоот тушаал
5	Дотоодын нийт бүтээгдэхүүнийг улирлаар тооцох аргачлал	ҮСХ-ны даргын 2013 оны 11-р сарын 26-ны өдрийн 01/134 тоот тушаал
6	Үндэсний тооцооны данс байгуулах шинэчилсэн аргачлал	ҮСХ-ны даргын 2013 оны 11-р сарын 26-ны өдрийн 01/134 тоот тушаал
7	Боловсролын салбарын ангилал, үзүүлэлт тооцох шинэчилсэн аргачлал	ҮСХ-ны даргын 2013 оны 12-р сарын 16-ны өдрийн 01/145 тоот тушаал
8	Соёлын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал	ҮСХ-ны даргын 2013 оны 12-р сарын 16-ны өдрийн 01/144 тоот тушаал
9	Ядуурлын үзүүлэлт тооцох аргачлал	ҮСХ-ны даргын 2013 оны 12-р сарын 06-ны өдрийн 01/135 тоот тушаал
10	Хүн амын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал	ҮСХ-ны даргын 2013 оны 12-р сарын 25-ны өдрийн 01/149 тоот тушаал
11	Нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцэл байгуулах аргачлал"-ыг шинэчлэх	ҮСХ-ны даргын 2013 оны 12-р сарын 25-ны өдрийн 01/151 тоот тушаал